



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 дугаар сарын 21

№ 01/17 АУА - 2018/51/СТА-ТЦЗ Мандалговь хот

Г

7

Төлбөр барагдуулах тухай

Аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар сахилгын шийтгэлтэй төрийн албан хаагчид 270,000.00 /хоёр зуун далан мянган/ төгрөгийн урамшуулалт олгосон зөрчил илэрлээ.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай хэмнүүлтэй байхаар төлөвлөж зарцуулах/, Төрийн албаны тухай хуулийн 26.6-д /Төрийн эжихэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойши нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно./, Улсын Их Хурлын 2017 оны 67-р тогтоолын 1.1-д /2017 оны төсвийн эжилд төрийн ондөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчид 300000 төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулалт олгох/;, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлд: /Улсын Их Хурлын 2017 оны 67-р тогтоолын дагуу 2017 онд төрийн ондөр албан тушаалтан, шүүгч прокуророос бусад төрийн албан хаагчид 300000 төгрөгийн урамшуулалт олгох тухай асуудлыг хэлэлцээд сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулалт олгох арга хэмжээ авахыг төсвийн шууд захирагч наарт даслагав/ гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.7-д /Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал/ гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:


1. Урамшуулалт олгосон 270,000.00 /хоёр зуун далан мянган/ төгрөгийг Ё.Энхмөнхөөр нехөн төлүүлж 100080000955 дугаар дансанд 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор тус тус төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2018 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Дэлгэрхангай сумын ЕБС-ийн эрхлэгч Ж.Өлзийжаргал, нягтлан бодогч Т.Дулмаа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН¹: 
АУДИТОР: Г.БАТСАЙХАН

4817144213
ЗЮА0039 9033475

ЗӨВШӨӨРСӨН: 
ЭРХЛЭГЧ: Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ
НЯГТЛАН БОДОГЧ: Г.ДУЛМАА

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангаадаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцааг албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.